

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ

1 дүгээр зүйл. Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болохоос өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн намыг ~~энэ хуульд нийцүүлэн~~ дахин бүртгэхгүй.

~~**2 дугаар зүйл.** Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хуультай нийцүүлэх арга хэмжээг уг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 6 сарын дотор авах бөгөөд энэхүү өөрчлөлтөө Улсын дээд шүүх, сонгуулийн төв байгууллагад 30 хоногийн дотор хүргүүлнэ.~~

2 дугаар зүйл. Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх арга хэмжээг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш зургаан сарын дотор авч хэрэгжүүлэх бөгөөд энэхүү өөрчлөлтөө Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ.

3 дугаар зүйл. Намд үзүүлэх төрийн санхүүжилтийг Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус сонгуулийн үр дүнгээр бүрдэх Улсын Их Хурлын шинэ бүрэн эрх эхэлсэн цагаас эхлэн олгоно.

4 дүгээр зүйл. Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө байгуулагдсан намын харьяа байгууллага уг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 6 зургаан сарын дотор Улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлнэ. Намын харьяа байгууллагыг шинэчлэн бүртгэхэд улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлнө.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 2023.07.03
Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2005 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр баталсан Улс төрийн намын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

~~2 дугаар 1 дүгээр зүйл.~~ Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт 16 дугаар зүйл нэмсүгэй:

“16 дугаар зүйл. Улс төрийн намыг бүртгэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

16.1. Намыг бүртгэхэд доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

16.1.1. гэрчилгээ олгоход 300 000 төгрөг;

16.1.2. намын нэр сольсныг бүртгэхэд 150 000 төгрөг.”

~~2 дугаар зүйл.~~ Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “Улс төрийн нам, шашны байгууллагыг” гэснийг “Шашны байгууллагыг” гэж, 15.2.3, 15.2.4, 15.2.5 дахь заалтын дугаарыг “15.2.1, 15.2.2, 15.2.3” гэж тус тус өөрчилсүгэй.

~~1 дүгээр зүйл.~~ Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн доор дурдсан хэсгийн хөлбөгдөх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай:

~~15.2. “Улс төрийн нам,”;~~

~~“15.2.1. улс төрийн намыг бүртгэж, гэрчилгээ олгоход 60 000–150 000 төгрөг;”;~~

~~“15.2.2. улс төрийн намын нэр сольсныг бүртгэхэд 20 000–50 000 төгрөг;”.~~

3 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 15.2.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

~~3 дугаар 4 дүгээр зүйл.~~ Энэ хуулийг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах заалт
17.2 дугаар зүйл нэмсүгэй:

1/17.2 дугаар зүйл:

“17.2 дугаар зүйл. Улс төрийн намын тухай хуулийг зөрчих

17.2.1.1. Нам нь Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6-д заасан хориглолтыг зөрчсөн бол арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;

17.2.2.2. Монгол Улсын иргэд нам үүсгэн байгуулахад дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцсон бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;

17.2.3.3. Намын хяналтын байгууллагад байгууллагын хараат бус байдалд хөндлөнгөөс нөлөөлөхийг оролдсон бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;

17.2.4.4. Нам хуульд заасны дагуу өөрчлөн байгуулагдсан тохиолдолд түүний өмч, хөрөнгийг тус намын гишүүн болон бусад иргэн, хуулийн этгээд аливаа хэлбэрээр өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэсэн бол хүнийг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;

17.2.5.5. Нам нь Улс төрийн намын тухай хуулийн 26.1-д заасан орлогыг нэг банк дахь нэг дансаар хүлээн аваагүй бол арван мянган нэгжтэй банкны нэг дансаар хүлээн аваагүй бол тухайн орлогын мөнгөн дүнг хоёр дахин үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;

17.2.6.6. Нам нь иргэний болон хуулийн этгээдийн хандивыг бэлэн мөнгөөр хүлээн авсан бол арван мянган нэгжтэй тухайн мөнгөн дүнг хоёр дахин үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;

17.2.7.7. Нам нь нэг жилд нэг иргэн, хуулийн этгээдээс авах хандивын дээд хэмжээг хуульд зааснаас хэтрүүлэн авсан бол арван мянган нэгжтэй тухайн хандивийн мөнгөн дүнг хоёр дахин үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;

~~17.2.8.8.~~ Намаас бусад хуулийн этгээд нам гэсэн оноосон нэр хэрэглэсэн бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

~~1 дүгээр зүйл. Шилэн дансны тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:~~

~~1/3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалт:~~

~~“3.1.6. төрийн санхүүжилт авч буй нам, эвсэл;”~~

~~2 дугаар зүйл. Шилэн дансны тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:~~

~~1/6 дугаар зүйлийн 6.11 дэх хэсэг:~~

~~“6.11. Улс төрийн намын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу төрийн санхүүжилт авч буй нам, эвсэл энэ хуулийн 3.1.6-д заасны дагуу төрийн санхүүжилтийн төсөвт өртөг, зарлага, санхүүжилтийн мэдээлэл, тайланг хуульд өөрөөр заагаагүй бол жил бүр сонгуулийн төв байгууллагаас тогтоосон журмын дагуу гаргаж намын цахим хуудас, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байрлуулна.~~

~~1 дүгээр зүйл. Шилэн дансны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:~~

~~1/3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалт:~~

~~“3.1.6. төрийн санхүүжилт авч буй нам, эвсэл.”~~

~~2/6 дугаар зүйлийн 6.11 дэх хэсэг:~~

~~“6.11. Улс төрийн намын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу төрийн санхүүжилт авч буй нам, эвсэл энэ хуулийн 3.1.6-д заасны дагуу төрийн санхүүжилтийн төсөвт өртөг, зарлага, санхүүжилтийн мэдээлэл, тайланг хуульд өөрөөр заагаагүй бол жил бүр сонгуулийн төв байгууллагаас тогтоосон журмын дагуу гаргаж намын цахим хуудас, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байрлуулна.~~

~~3 2 дугаар зүйл. Энэ хуулийг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.~~

Төсөл 2023.07.03
Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8 дахь хэсгийг заалтыг доор дурдсанаар өөрчилсүгэй:

“25.8.8. Улс төрийн намыг бүртгэх, бүртгэхээс татгалзах, идэвхгүй болон идэвхтэйд тооцох, татан буулгах, тамга тэмдгийн хяналтын, регистрийн, хувийн хэргийн дугаар, гэрчилгээ олгох, хүчингүй болгох, эдгээртэй холбогдсон бүртгэл болон намын нэрийн сан хөтлөх, лавлагаа олгох;”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
ХОТ

СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

~~1 дүгээр зүйл. Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлд доор дурдсан нэмэлт, өөрчлөлт оруулсугай:~~

~~1/4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дэх хэсэг:~~

~~“4.1. Хөрөө нь өсөн гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн тав нь орон төөны, дөрөв нь орон төөны бус байна.”~~

~~2/4 дүгээр зүйлийн 4.2 дах хэсэг:~~

~~4.2. Хөрөөны гишүүнийг хараат бусаар сонгон шалгаруулж, Улсын Их Хурал нэр дөвшигчийн сонсгол хийх замаар зургаан жилийн хугацаагаар томилно. Хөрөөны гишүүний тавыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хөрөө, хоёрыг Монгол Улсын Ерөнхийлөгч, хоёрыг Улсын дээд шүүх төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгоно.”~~

2 дугаар 1 дүгээр зүйл. Сонгуулийн төв байгууллагын тухай жуульд доор дурдсан зүйл, заалт хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.6 дахь хэсэг нэмсүгэй:

~~1/3 дугаар зүйлийн 3.11 дэх хэсэг:~~

~~“3.11. Хөрөөны дүрмийг Улсын Их Хурал батална.”~~

~~2/7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэг:~~

7.6. Хөрөө улс төрийн намын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.6.1. намыг бүртгүүлэх өргөдлийн маягтыг батлах;

7.6.2. намыг бүртгүүлэх өргөдөл, хөлбөгдөх баримт бичгийг нягтлан шалгах, нэмэлт мэдээлэл гаргуулахаар шаардах;

7.6.3. намын бүртгэлийн жагсаалт, бүртгэлийн хувийг хэрэг хөтлөх;

7.6.4. намын оршин байх албан ёсны хаяг, хөрөнгийн өөрчлөлтийг бүртгэх;

7.6.5. намд өгөх хандивын бүртгэлийг хөтлөх маягтыг батлах;

7.6.6. хуульд заасан үндэслэл журмын дагуу намыг тараах тухай дүгнэлт гаргах;

~~7.6.7.намын бүртгэлд үндэслэн хуулийн этгээдийн гэрчилгээ, тамга, тэмдэг олгох;~~

~~7.6.8.намд олгох төрийн санхүүжилтийн тооцож төсөвт суулган олгох;~~

~~7.6.9.намд олгох төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоож;~~

~~7.6.10.намд олгох шууд бус дэмжлэгийг олгох, шийдвэрлэх;~~

~~7.6.11.намын үйл ажиллагаанд хэрэглэх цахим программ хангамжийг баталгаажуулах;~~

~~7.6.12.намын албан ёсны цахим хуудас, нийгмийн сүлжээний хаяг, хөлбөгдөх өөрчлөлтийг бүртгэх;~~

~~7.6.13.Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8-д заасны дагуу хэрэгжүүлэх хяналт;~~

~~7.6.14.Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д заасны дагуу хэрэгжүүлэх хяналт;~~

~~7.6.15.Улс төрийн намын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу намыг идэвхгүйд тооцох эсэх тухай шийдвэр гаргах;~~

~~7.6.16.Улс төрийн намын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.13-т заасны дагуу намд хяналт тавих;~~

~~7.6.17.Улс төрийн намын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.13-т заасны дагуу намд хяналт тавих;~~

~~7.6.18.Улс төрийн намын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.13-т заасны дагуу намд хяналт тавих;~~

~~7.6.19.Улс төрийн намын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т заасны дагуу намын санхүүгийн тайланд хяналт тавих;~~

~~7.6.20.Улс төрийн намын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д заасны дагуу намын санхүүгийн тайланд хяналт тавих.~~

“7.6.Хороо улс төрийн намын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.6.1.Улс төрийн намын тухай хуулийн 9.10-т заасан мэдээллийн сан бүрдүүлж, нийтэд мэдээлэх;

7.6.2.төрийн санхүүжилт авах тухай хүсэлт гаргах маягыг батлах;

7.6.3.намд өгөх хандивын бүртгэлийг хөтлөх маягыг батлах;

7.6.4.хуульд заасан үндэслэл, журмын дагуу намыг тараах тухай санал гаргах;

7.6.5.намд олгох төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоож, төсөвт суулган олгох;

7.6.6.намд төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг олгох, шийдвэрлэх;

7.6.7.Улс төрийн намын тухай хуулийн 8.9, 10.3-т заасны дагуу хяналт хэрэгжүүлэх;

7.6.8.Улс төрийн намын тухай хуулийн 26.6-д заасны дагуу шийдвэр гаргах;

7.6.9.улс төрийн намын санхүүгийн тайланд хяналт тавих;

7.6.10.Улс төрийн намын тухай хуульд заасан бусад бүрэн эрх.”

2 дугаар зүйл.Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “ажлын албанд” гэснийг “Тамгын газарт” гэж, 15 дугаар зүйлийн гарчгийн “ажлын алба” гэснийг “Тамгын газар” гэж, 15.1 дэх хэсгийн “ажлын албатай” гэснийг “Тамгын газартай” гэж, мөн хэсгийн “Хороо батална.” гэснийг “Хороо батална. Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг Хорооны даргын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.” гэж, 15.2 дахь хэсгийн “ажлын албаны” гэснийг “Тамгын газрын” гэж тус тус өөрчилсүгэй.”

3 дугаар зүйл.Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь дугаарыг “7.7”, 7 дугаар зүйлийн 7.7 дахь дугаарыг “7.8” 7.6, 7.7 дахь хэсгийн дугаарыг “7.7, 7.8” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

~~Улс төрийн намын тухай хууль батлагдсантай~~ Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

~~1.Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан Улс төрийн намын тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдрөөс хойш энэхүү хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нарийвчилсан журам, эхлэх хүртэлх хугацаанд арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо /П.Дэлгэрнарэн/ д нарт тус тус даалгасугай.~~

1.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан уг хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс хойш энэ хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг шийдвэрлэх, арга хэмжээг авах, холбогдох журмыг батлахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо /П.Дэлгэрнарэн/-нд тус тус даалгасугай.

~~2.Энэ тогтоолын хэрэгжилтэд биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/, Төсвийн байнгын хороо /Г.Тэмүүлэн/ нарт нд тус тус үүрэг бөлгөсугай даалгасугай.~~

~~3.Энэхүү тогтоолыг 2023 оны ... дугаар сарын ... ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.~~

3.Энэ тогтоолыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг